




САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО



**ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН  
2017 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ТОЙМ**



УЛААНБААТАР ХОТ  
2017

## АГУУЛГА

<b>1. ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД</b>	<b>3</b>
1.1. Зах зээлийн үнэлгээ	3
1.2. Зах зээлийн үнэлгээ (ЗЗҮ)-ний дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-д эзлэх хувь, хөрвөх чадварын түвшин	4
1.3. Үнэт цаасны зах зээлийн индексүүд	5
<b>2. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОГЧИД</b>	<b>5</b>
2.1. Хувьцаат компаниуд	5
2.2. Зохицуулалттай этгээдүүд	7
<b>3. ЗАХ ЗЭЭЛ ДЭХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ</b>	<b>9</b>
3.1. Хувьцааны арилжаа	9
3.2. Засгийн газрын үнэт цаас /ЗГҮЦ/-ны арилжаа	9
3.3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа	10
3.4. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа	11
<b>4. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ ТАЛЫН ХҮЧИН ЗҮЙЛС</b>	<b>11</b>
4.1. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үзүүлэлтүүд	12

## ЗУРАГ

Зураг 1. Зах зээлийн үнэлгээ /тэрбум төгрөг/	3
Зураг 2. ЗЗҮ/ДНБ /хувиар/	4
Зураг 3. Хөрвөх чадварын түвшин	5
Зураг 4. ТОП-20 индекс	5
Зураг 5. Хувьцаат компанийн тоо	6
Зураг 6. Нийт арилжааны үнийн дүнд эзлэх хувь	10
Зураг 7. ҮЦТХТ-д нээгдсэн дансны тоо	11
Зураг 8. Хөрөнгө оруулагчдын арилжаанд эзлэх хувь	12

## ХҮСНЭГТ

Хүснэгт 1. Зах зээлийн үнэлгээ өндөр 30 компани	4
Хүснэгт 2. Хувьцаат компанийн өмчийн хэлбэр, тоо	7
Хүснэгт 3. Хувьцаат компанийн хувьцааны бүтэц	7
Хүснэгт 4. Ногдол ашгийн гэрээ байгуулсан компани	8
Хүснэгт 5. Зохицуулалттай этгээдийн тоо	8
Хүснэгт 6. Нийт хөрөнгө /тэрбумтөгрөгөөр/	9
Хүснэгт 7. Нийт орлого /сая төгрөгөөр/	9
Хүснэгт 8. Үнэт цаасны арилжааны үзүүлэлт	10
Хүснэгт 9. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас /тэрбум төгрөг/	11
Хүснэгт 10. ХААБ-ийн арилжааны үнийн дүн, хэмжээ	12

## ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ


Үнэт цаасны зах зээлийн 2017 оны 1 дүгээр улирлын тоймоор салбарын хөгжлийг илэрхийлэгч үзүүлэлтүүд болох зах зээлийн үнэлгээ, хөрвөх чадвар, хувьцааны индекс, бүртгэлтэй компанийн тоог өмнөх оны мөн үетэй харьцуулан авч үзлээ. Түүнчлэн үнэт цаасны зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг илэрхийлэгч үзүүлэлтүүд болон дэд бүтцийн төлбөр тооцоо, хадгаламжийн үзүүлэлтүүд, үнэт цаасны арилжааны дүн, зохицуулалттай этгээд болон хөрөнгө оруулагчдын үнэт цаасны арилжаанд эзлэх оролцоог хураангуй байдлаар харуулав.

### 1. ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

#### 1.1. Зах зээлийн үнэлгээ

Үнэт цаасны зах зээлийн багтаамж, түүний эдийн засгийн өсөлтийг дунд болон урт хугацаанд дэмжигч гол үзүүлэлт нь үнэт цаасны зах зээлийн үнэлгээ бөгөөд энэхүү үзүүлэлтийн өсөлт, бууралт нь үнэт цаасны зах зээлийн хөгжлийн түвшинг, улмаар эдийн засгийн хөгжилд хэрхэн нөлөө үзүүлж байгааг илэрхийлэгч үндсэн индикатор болдог.

Зураг 1. Зах зээлийн үнэлгээ /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2017 оны 1 дүгээр улирлын байдлаар үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 1,429.2 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 131.9 тэрбум төгрөг буюу 10.2 хувиар өссөн үзүүлэлт юм. Тайлант хугацаанд нийт 62 удаагийн арилжаагаар 94 компанийн 28.9 сая ширхэг хувьцааг 5.0 тэрбум төгрөгөөр арилжсан байна. Нийт 94 компанийн үнэт цаас арилжигдсанаас өмнөх оны мөн үетэй харьцуулахад 32 компанийн үнэт цаасны ханш өсч, 52 компанийн үнэт цаасны ханш буурч, 10 компанийн үнэт цаасны ханш тогтмол байлаа.

Тайлант хугацаанд нийт зах зээлийн үнэлгээний 90.3 хувийг 30 компани бүрдүүлсэн байна. Үүнд:

Хүснэгт 1. Зах зээлийн үнэлгээ өндөр 30 компани


№	ҮНЭТ ЦААСНЫ НЭР	ҮНЭЛГЭЭ /ТЭРБУМ ТӨГРӨГ/	№	ҮНЭТ ЦААСНЫ НЭР	ҮНЭЛГЭЭ /ТЭРБУМ ТӨГРӨГ/
1	АПУ	256.0	16	ТАЛХ ЧИХЭР	20.6
2	ТАВАН ТОЛГОЙ	214.0	17	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	19.9

3	МИК ХОЛДИНГ	211.2	18	БАЯНГОЛ ЗБ	17.3
4	ГОВЬ	92.3	19	БЭРХ УУЛ	15.2
5	УБ БҮК	47.4	20	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	13.6
6	СҮҮ	46.4	21	ГЕРМЕС ЦЕНТР	11.7
7	МОНГОЛ ШУУДАН	37.3	22	МАТЕРИАЛИМПЕКС	11.6
8	БАГАНУУР	35.7	23	АТАР ӨРГӨӨ	10.8
9	ШИВЭЭ ОВОО	29.5	24	ТЕХНИКИМПОРТ	10.2
10	МОНГОЛ СЕКЬЮРИТИЕС	26.7	25	СИЛИКАТ	9.5
11	ТАХЬ КО	25.7	26	МАХИМПЕКС	9.5
12	ШАРЫН ГОЛ	23.4	27	АРИГ ГАЛ	8.2
13	БИДИСЕК	22.8	28	ХАЙ БИ ОЙЛ	6.8
14	ДАРХАН НЭХИЙ	22.8	29	АДУУНЧУЛУУН	6.3
15	ГУТАЛ	22.4	30	МОНГОЛ ШИЛТГЭЭН	6.0

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


## 1.2. Зах зээлийн үнэлгээ (ЗЗҮ)-ний дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-д эзлэх хувь, хөрвөх чадварын түвшин

2017 оны 1 дүгээр улирлын байдлаар ЗЗҮ-ний нэрлэсэн ДНБ-д эзлэх хувь 25.0 болсон нь өмнөх оны мөн үеийнхээс 2.6 хувиар буурсан, хөрвөх чадварын түвшин 0.35 болж өмнөх оны мөн үеийнхээс 0.29 нэгжээрбуурсан хандлага ажиглагдлаа. 2011 оноос хойш ДНБ-болон ЗЗҮ нь урвуу хамааралтай өөрчлөлт үзүүлсэн нь манай улсын үнэт цаасны зах зээл болон эдийн засгийн өсөлтийн хооронд хамаарал сул байгааг илтгэж байна.



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зураг 3. Хөрвөх чадварын түвшин




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

### 1.3. Үнэт цаасны зах зээлийн индексүүд

Тайлант хугацаанд ТОП-20 индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1368.39 нэгжээр буюу 12.35 хувиар өсч, 12,451.01 нэгж болсон бөгөөд индексийн дээд үзүүлэлт 13,167.83 нэгж, доод үзүүлэлт 11,972.11 нэгж, дундаж үзүүлэлт 12,353.67 нэгж байна.

Тайлант хугацаанд MSE ALL индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 17.56 нэгжээр буюу 2.19 хувиар өсч, 820.49 нэгж болсон бөгөөд индексийн дээд үзүүлэлт 867.98 нэгж, доод үзүүлэлт 814.51 нэгж, дундаж үзүүлэлт 842.14 нэгж байна.

Зураг 4. ТОП-20 индекс




Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

## 2. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОГЧИД

### 2.1. Хувьцаат компаниуд

Тайлант хугацаанд Хорооны үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлд нийт 302 компани бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 5. Хувьцаат компанийн тоо



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Монголын хөрөнгийн биржийн бүртгэлээс хасагдсан боловч Хороонд бүртгэлтэй 66 компани байгаа ба Хороонд бүртгэлтэй дээрх 302 хувьцаат компанийг өмчийн хэлбэрээр нь аваад үзвэл 50 компани буюу 17 хувь нь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой байв.

Хүснэгт 2. Хувьцаат компанийн өмчийн хэлбэр, тоо

Үнэт цаас гаргагчийн өмчийн бүтэц	“ҮЦТХТ” ХХК	“Монголын хөрөнгийн бирж” ХК	СЗХ
Төрийн өмчит	35	21	31
Төрийн өмчийн оролцоотой	9	16	19
Хувийн өмчит	273	199	252
<b>Нийт</b>	<b>317</b>	<b>236</b>	<b>302</b>

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжинд 2017 оны 3дугаар улирлын байдлаар нийт 317 ХК-ийн 1,4 их наяд төгрөгийн зах зээлийн үнэлгээ бүхий 22,226,429,650 ширхэг үнэт цаас хадгалагдаж байна. Үүнээс:

- Нээлттэй ХК-ийн бүртгэлд 312 ХК-ийн 7,011,980,050 ширхэг хувьцаа, үүнээс төрийн өмчтэй 34 ХК-ийн 2,818,123,684 ширхэг хувьцаа, орон нутгийн өмчтэй 9 ХК-ийн 29,045,916 хувьцаа, төр, 268 ХК байна.
- Хаалттай ХК-ийн бүртгэлд 5 ХК-ийн 15,214,449,600 ширхэг хувьцаа хадгалагдаж байгаагаас төрийн өмчийн 1 ХК-ийн /Эрдэнэс тавантолгой ХК/ 12,782,610,659 ширхэг хувьцаа байна.

Хүснэгт 3. Хувьцаат компанийн хувьцааны бүтэц

Үнэт цаас гаргагчийн ангилал	2015 он	2016 он	2017-I
Төрийн мэдлийн бус хувьцаа	2,809,930	4,160,854	4,164,810
Төрийн мэдлийн хувьцаа	2,246,316	2,818,124	2,818,124
Орон нутгийн оролцоотой	29,046	29,046	29,046

<b>Нийт</b>	<b>5,085,292</b>	<b>7,008,024</b>	<b>7,011,980</b>
Эрдэнэс Тавантолгой /Иргэн/	2,558,176	2,212,224	2,212,224
Эрдэнэс Тавантолгой /ААН/	5,139	5,203	5,239
Эрдэнэс Тавантолгой /Төр/	12,436,685	12,782,573	12,782,537
<b>Нийт</b>	<b>15,000,000</b>	<b>15,000,000</b>	<b>15,000,000</b>
Хаалттай ХК	172,753	174,958	214,450
<b>Нийт</b>	<b>172,753</b>	<b>174,958</b>	<b>214,450</b>

Эх сурвалж: “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК

2017 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 4 ХК-тай ногдол ашгийн гэрээ байгуулж, үйлчилгээний хөлс 1,071,500 төгрөг тооцож нийт 7,515 харилцагчийн дансанд 557,612, 537.64 төгрөгийн ногдол ашгийг байршуулсан.

**Хүснэгт 4. Ногдол ашгийн гэрээ байгуулсан компани**

№	ҮЦ Код	ҮЦ-ны нэр	Ногдол ашгийн огноо	Бүртгэх өдөр	Нэгж ногдол	ҮЦТХТ ХХК-иар зуучлуулан тараах		
						ХЭ-ийн тоо	ҮЦ-ны тоо	Мөнгөн дүн
1	458	"Таван толгой" ХК	2013	14.03.15	689,4	954,0	486 126,0	335 135 264,4
2	458	"Таван толгой" ХК	2013	14.03.15	53,1	1035,0	604 859,0	32 118 012,9
3	458	"Таван толгой" ХК	2013	14.03.15	180,0	1037,0	578 723,0	104 170 140,0
4	458	"Таван толгой" ХК	2015	15.03.09	53,1	1089,0	615 058,0	326 598 579,8
5	379	"Материалимпекс" ХК	2015	16.02.16	27,0	1598,0	202 612,0	5 470 524,0
6	379	"Материалимпекс" ХК	2009, 2011, 2012, 2013	-	-	8,0	81 134,0	5 112 047,1
7	528	"Гермес центр" ХК	2016	17.02.22	3,7	932,0	11 178 284,0	40 912 519,4
8	195	"Улаанбаатар БҮК" ХК	2014	15.03.16	5940,0	862,0	34 520,0	2 034 450,0
<b>Нийт дүн</b>						<b>7515,0</b>	<b>13 781 046,0</b>	<b>557 612 537,6</b>

Эх сурвалж: “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК

**2.2. Зохицуулалттай этгээдүүд**

Тайлант хугацаанд 62 ҮЦК Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байгаагаас үнэт цаасны арилжаа эрхлэх 2, үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх 1, төвлөрсөн хадгаламжийн 1, кастодиан банкны үйлчилгээ үзүүлэх 3, хөрөнгө оруулалтын менежментийн 14 компани үйл ажиллагаа явуулж байгаа бол хөдөө аж ахуйн биржийн арилжаа, зуучлалын чиглэлээр арилжаа эрхлэх 1, бараа, түүхий эдийн арилжааны зуучлалын үйл ажиллагаа эрхлэх 15 этгээд тусгай зөвшөөрөлтэй байна. Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж буй зохицуулалттай этгээдүүдийг хүснэгтээр үзүүлбэл:

**Хүснэгт 5. Зохицуулалттай этгээдийн тоо**

№	Зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэгч	Оролцогчдын тоо
1	Үнэт цаасны арилжаа эрхлэх	2
2	Үнэт цаасны төлбөр тооцооны	1



3	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн	1
4	Хөрөнгө оруулалтын менежментийн	14
5	Брокер, дилер	62
6	Кастодиан банк	3
7	Андеррайтер /давхардсан тоогоор/	25
8	Хөрөнгө оруулалтын зөвлөх /давхардсан тоогоор/	15
<b>Нийт</b>		<b>83</b>
9	Хөдөө аж ахуйн түүхий эдийн арилжаа эрхлэх	1
10	Хөдөө аж ахуйн түүхий эдийн брокер	15
11	Аудитын компани	47
12	Үнэлгээний компани	20
13	Хуулийн компани	20

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

**Мэргэжлийн оролцогчидын өнөөгийн нөхцөл байдал:** 2017 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт ҮЦК-иудын тоо 62 байгаа нь хөрөнгө оруулагчдын хувьд хангалттай хэмжээнд хүрсэн хэдий ч, санхүүгийн хувьд чадавхтай, үнэт цаасны арилжаанд идэвхтэй оролцдог, холбогдох хууль тогтоомж болон Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажилладаг компаниуд цөөн байгаа тул хөрөнгийн зах зээлийн хөгжлийг цаашид нэмэгдүүлэх, мэргэжлийн оролцогч байгууллагуудыг чадавхжуулах замаар үнэт цаасны арилжааны хэмжээ, хөрвөх чадвар болон гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай тулгарч байна.

**Хүснэгт 6. Нийт хөрөнгө /тэрбум төгрөгөөр/**

№	Үндсэн үзүүлэлтүүд	2016	2017-I	Өсөлт/бууралт
1	Эргэлтийн хөрөнгийн дүн	71.6	70.2	-2%
2	Эргэлтийн бус хөрөнгө	19.7	18.9	-4%
3	<b>Нийт актив</b>	<b>91.3</b>	<b>89.1</b>	<b>-2,4%</b>
4	Өр төлбөр	24.5	20.5	-16%
5	Эздийн өмч	66.8	68.6	2,7%
6	<b>Нийт пассив</b>	<b>91.3</b>	<b>89.1</b>	<b>-2,4%</b>

Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

2017 оны 1 дүгээр улиралын байдлаарх тайлан балансын нэгтгэлд санхүүгийн тайлангаа ирүүлсэн 53 брокер, дилерийн компаниас нэр бүхий 19 ҮЦК нь ашигтай, 34 ҮЦК нь алдагдалтай, 8 ҮЦК нь тухайн хугацаанд үйл ажиллагаа явуулаагүй байдалтай байна.

**Хүснэгт 7. Нийт орлого /сая төгрөгөөр/**

№	Орлогын хураангуй тайлан	2016	2017-I
1	Үйл ажиллагааны орлого	5,492.16	2178.478
2	Ногдол ашгийн орлого	493.08	2.551712
3	Борлуулалт маркетингийн болон ерөнхий ба удирдлагын зардал	6,097.59	1792.526
4	Ажиллагчдын цалингийн зардал	2,778.28	974.472
5	Албан татвар, төлбөр, хураамжийн зардал	847.70	245.056
6	Санхүүгийн зардал	588.05	836.5695
7	Бусад зардал	82.37	21.87164

8	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	641.35	-59.627
9	Бусад ашиг (алдагдал)	-384.05	-11.2978
10	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>1,134.58</b>	<b>-29.961</b>
11	Орлогын татварын зардал	117.96	22.48423
12	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>1,016.61</b>	<b>-52.4452</b>

Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

Үнэт цаасны зах зээлд брокер, дилер, андеррайтерийн компаниудын тоо /давхардсан тоогоор/ 2010-2012 оны хооронд 95 болж, огцом өссөн. Дээрх өсөлтөд голлох нөлөө үзүүлсэн нь төрөөс “Эрдэнэс таван толгой” ХК-ийн 1072 ширхэг хувьцааг Монгол Улсын иргэн бүрт үнэ төлбөргүй эзэмшүүлэх шийдвэр гаргасан нь үнэт цаасны зах зээлд мэргэжлийн зуучлагчид болох брокер, дилерийн компаниудын тоо огцом өсөхөд хүргэсэн.

### 3. ЗАХ ЗЭЭЛ ДЭХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ

2017 оны 1 дүгээр улиралд “Монголын хөрөнгийн бирж” ХК-аар дамжуулан нийт 138.3 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3 дахин өсчээ. Нийт арилжааны үнийн дүнгийн 3.6% буюу 5.0 тэрбум төгрөгийг хувьцааны арилжаа, 86.4% буюу 119.5 тэрбум төгрөгийг ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаа, 10.0% буюу 13.8 тэрбум төгрөгийг ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаа тус тус эзэлж байна.

#### Хүснэгт 8. Үнэт цаасны арилжааны үзүүлэлт

Үнэт цаасны төрөл		Арилжигдсан тоо хэмжээ /сая ширхэг/	Арилжааны үнийн дүн/тэрбум төгрөг/
Хувьцаа	Анхдагч зах зээл	-	-
	Хоёрдогч зах зээл	28.9	5.0
ЗГҮЦ	Анхдагч зах зээл	1.3	119.5
	Хоёрдогч зах зээл	0.1426	13.8

Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

#### 3.1. Хувьцааны арилжаа


2017 оны 1-р улиралд нийт 62 удаагийн арилжаагаар 94 компанийн 28.9 сая ширхэг хувьцааг 5.0 тэрбум төгрөгөөр арилжсан байна. Нийт 94 компанийн үнэт цаас арилжигдсанаас өмнөх оны мөн үетэй харьцуулахад 32 компанийн үнэт цаасны ханш өсч, 52 компанийн үнэт цаасны ханш буурч, 10 компанийн үнэт цаасны ханш тогтмол байлаа. Идэвхтэй арилжигдсан 20 үнэт цаасны тоо ширхэг нь нийт арилжигдсан ширхэгийн 99.68 хувь, үнийн дүнгийн 95.86 хувийг тус тус эзэлж байна.

#### 3.2. Засгийн газрын үнэт цаас /ЗГҮЦ/-ны арилжаа

**Анхдагч зах зээлийн арилжаа:** Тайлант хугацаанд ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаа 11 удаа явагдаж, 12, 28, 39, 52, 104, 156 долоо хоногийн хугацаатай нийт 1.3 сая ширхэг үнэт цаасыг 119.5 тэрбум төгрөгөөр арилжаад байна.

**Хоёрдогч зах зээлийн арилжаа:** Тайлант хугацаанд ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлд 142.6 мянган ширхэг үнэт цаасыг 13.7 тэрбум төгрөгөөр арилжсан байна. Нийт арилжааны үнийн дүнгийн 3.6%-ийг хувьцааны арилжаа, 10.0%-ийг ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаа, 86.4%-ийг ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаа тус тус эзэлж байна.

**Зураг 6. Нийт арилжааны үнийн дүнд эзлэх хувь**



Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

### 3.3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа

Өнгөрөгч онд Хорооны 2016 оны 305 дугаар тогтоолоор “МИК Актив арав” ХХК-ийн 1,030,173 ширхэг, 307 дугаар тогтоолоор “МИК Актив арван нэг” ХХК-ийн 709,007 ширхэг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг тус тус бүртгээд байна.

**Хүснэгт 9. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас /тэрбум төгрөг/**

ХБҮЦ гаргагч	Нийт гаргасан үнэт цаас	"ҮЦТХТ" ХХК-д бүртгэгдсэн	Зээлдэгчийн тоо
“МИК активнэг ТЗК” ХХК	328.1	322.9	6,658
“МИК активхоёр ТЗК” ХХК	224.8	222.1	5,290
“МИК активгурав ТЗК” ХХК	328.5	324.6	6,593
“МИК активдөрөв ТЗК” ХХК	459.4	452.3	9,510
“МИК активтав ТЗК” ХХК	301.2	294.3	5,805
“МИК активзургаа ТЗК” ХХК	267.8	261.7	5,188
“МИК активдолоо ТЗК” ХХК	299.6	293.8	5,414
“МИК актив найм ТЗК” ХХК	189.8	186.3	3,291
“МИК актив ес ТЗК” ХХК	137.5	137.2	1,719
“МИК актив арав ТЗК” ХХК	103.0	-	1,585
“МИК актив арван нэг ТЗК” ХХК	70.9	-	1,135
<b>Нийт</b>	<b>2,710.6</b>	<b>2,495</b>	<b>52,188</b>

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2017 оны 1 дүгээр улирлын байдлаар үндсэн ба хүүгийн төлбөр төлөгдсөн “МИК Актив Нэг” бондоос 68,602 ширхэг, “МИК Актив Хоёр” бондоос 45,534 ширхэг, “МИК Актив Гурав” бондоос 61,738 ширхэг, “МИК Актив Дөрөв” бондоос 91,560 ширхэг, “МИК Актив Тав” бондоос 52,809 ширхэг, “МИК Актив Зургаа” бондоос 44,912 ширхэг, “МИК Актив Долоо” бондоос 41,403 ширхэг, “МИК Актив Найм” бондоос 32,082 ширхэг, “МИК Актив Ес” бондоос 15,785 ширхэгийг тус тус хасаж, үндсэн бүртгэлд өөрчлөлт оруулсан.

### 3.4. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа

2017 оны I улиралд нийт 34 удаагийн арилжаагаар 30.8 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий спот гэрээний арилжаа хийсэн ба өдрийн дундаж арилжаа 907,8 сая төгрөг байсан. Хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийн нэр төрөл бүрээр арилжааны дүн болон хэмжээг дараах байдлаар харуулав. Үүнд:

Хүснэгт 10. ХААБ-ийн арилжааны үнийн дүн, хэмжээ

№	Барааны нэр	Барааны хэмжээ /тонн/	Арилжааны дүн /тэрбум төгрөг/
1	Ноолуур	163.6	13.8
2	Хонины ноос	909.5	1.3
3	Тэмээний ноос	27.8	0,1
4	Ямааны зовод ноос	1051.6	14.9
5	Хонины завод ноос	517.8	0,6
	<b>Нийт</b>	<b>2670.3</b>	<b>30.8 тэрбум</b>

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


## 4. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ ТАЛЫН ХҮЧИН ЗҮЙЛС

“Монголын хөрөнгийн бирж” ХК-д хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш төвлөрсөн хадгаламжид өссөн дүнгээр нийт 890,780 данс, 140,165 холболтын данс нээгдсэн. Нийт дансыг бүтцээр нь үзвэл, 886,091 дотоодын иргэн, 1,948 гадаадын иргэн, 2,562 дотоодын аж ахуйн нэгж, 179 гадаадын аж ахуйн нэгжийн данс тус тус байна.

Тайлант хугацаанд үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид нийт 4,190 данс шинээр нээгдсэнээс 4,129 нь дотоодын иргэн, 28 нь гадаадын иргэн, 32 нь дотоодын аж ахуйн нэгж, 1 гадаадын аж ахуйн нэгжийн данс тус тус эзэлж байна.

Арилжааны бус хэлцэл болох өв залгамжлалын нийт 107 гүйлгээ хийгдэж, давхардсан тоогоор 109 ХК-ийн 183,792 ширхэг хувьцаа, бэлэглэлээр 48 гүйлгээ хийгдэж, давхардсан тоогоор 11 ХК-ийн 58,018 ширхэг хувьцааны өмчлөх эрхийг тус тус шилжүүлсэн байна.


Зураг 7. ҮЦГХТ-д нээгдсэн дансны тоо



Эх сурвалж: “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК

Тайлант хугацаанд “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн арилжааны үнийн дүнд гадаадын аж ахуйн нэгж болон иргэдийн эзлэх хувь 0.05 нэгж буюу 5.3 хувьтай байгаа бол дотоодын аж ахуйн нэгж болон дотоодын иргэдийн эзлэх хувь 0.95 нэгж буюу 94.7 хувьтай байна.

**Зураг 8. Хөрөнгө оруулагчдын арилжаанд эзлэх хувь**



Эх сурвалж: “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК

#### 4.1. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үзүүлэлтүүд

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид 317 ХК-ийн 1.4 их наяд төгрөгийн зах зээлийн үнэлгээ бүхий 22.2 тэрбум ширхэг үнэт цаас хадгалагдаж байгаагаас гадна 25 төрлийн 23.3 сая ширхэг компанийн бонд, 140 төрлийн 6.4 сая ширхэг Засгийн газрын бонд тус тус бүртгэлтэй байна. Үүнээс 22 төрлийн 23.1 сая ширхэг хөрөнгөөр баталгаажсан бонд, 874 төрлийн 3.1 сая ширхэг Засгийн газрын бонд биржийн бус зах зээл буюу хаалттай хэлбэрээр бүртгэгдсэн байна.

Мөн “Хөдөө аж ахуйн давхар даатгал” хаалттай ХК-ийн 150.0 сая ширхэг хувьцаа, “Ард санхүүгийн нэгдэл” хаалттай ХК-ийн 22.7 сая ширхэг хувьцаа, “Апи ресурс” хаалттай ХК-ийн 2.2 сая ширхэг хувьцаа, “Монгол базальт” ХК-ийн 39.4 сая ширхэг хувьцаа төвлөрсөн хадгаламжид тус тус бүртгэлтэй байна. Нийт Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэлтэй 312 ХК /хаалттай 5 ХК-ийг хасч тооцов/-ийн 22,011,980,050 ширхэг үнэт цаасны 70.87 хувийг төрийн өмчийн оролцоотой компанийн, 0.13 хувийг орон нутгийн оролцоотой компанийн, 29.0 хувийг төрийн мэдлийн бус буюу хувийн компанийн хувьцаа тус тус бүрдүүлж байна.

--oOo--